

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/050/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2026 оны 02 дугаар сарын 24

2026

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор:	Б.Мөнхбат
Утас: 70442584	Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер:	М.Алтантуяа
Утас: 99061829	Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитор:	Г.Энхзул
Утас: 99333147	Цахим хаяг: enkhzulg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2026.02.24 № 2/59
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Боловсролын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 9/61 дугаар “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” тогтоолоор 163,023.0 мянган төгрөгийн газрыг шилжүүлсэн байна.

6426050175

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-
албан тоот.docx

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
			/төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	73,050,056.64	105,165,773.94
33	АВЛАГА	4,917,524.64	45,847,930.94
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,917,524.64	52,553.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	28,795,377.94
335	Бусад авлага	0.00	17,000,000.00
33510	Байгууллагаас авах авлага	0.00	17,000,000.00
34	УРЬДЧИЛГАА	1,571.00	0.00
3471	Урьдчилгаа тооцоо	1,571.00	0.00
34713	Цалингийн урьдчилгаа	1,571.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	68,130,961.00	18,568,647.00
351	Түүхий эд материал	135,000.00	0.00
35110	Тусгай зориулалттай материал	135,000.00	0.00
354	Хангамжийн материал	67,995,961.00	18,568,647.00
35410	Бичиг хэргийн материал	2,517,510.00	689,510.00
35420	Аж ахуйн материал	63,550,815.00	16,484,137.00
35470	Бусад хангамжийн материал	1,927,636.00	1,395,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	40,749,196.00
36100	Барааны нөөц	0.00	40,749,196.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	791,772,064.73	598,456,641.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	791,772,064.73	598,456,641.24
392	Биет хөрөнгө	516,468,206.25	483,522,641.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	507,858,350.00	491,688,350.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(88,658,827.51)	(81,285,616.75)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,600,000.00	33,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(16,800,000.00)	(21,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	167,225,481.90	147,669,418.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(96,872,001.50)	(92,388,067.53)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,688,847.47	18,435,747.47
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,433,546.61)	(13,197,190.45)
39217	Ном	2,859,902.50	0.00
393	Биет бус хөрөнгө	275,303,858.48	114,934,000.00
39301	Програм хангамж	16,104,000.00	5,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(15,757,333.52)	(5,200,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	277,957,000.00	114,934,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(2,999,808.00)	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	864,822,121.37	703,622,415.18
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	94,850.75
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	94,850.75
413	Өглөг	0.00	94,850.75
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	254.41
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	94,596.34
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	864,822,121.37	703,527,564.43
51	Засгийн газрын хувь оролцоо	864,822,121.37	703,527,564.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	483,939,977.83	483,939,977.83
51101	Өмч: - төрийн	483,939,977.83	483,939,977.83
512	Хуримтлагдсан үр дүн	363,059,426.40	201,764,869.46
51210	Өмнөх үеийн үр дүн	496,991,647.05	366,059,234.40
51220	Тайлант үеийн үр дүн	(133,932,220.65)	(164,294,364.94)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,822,717.14	17,822,717.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	864,822,121.37	703,622,415.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,814,534,176.50	6,468,723,441.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,710,692,600.00	6,176,350,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,710,692,600.00	6,176,350,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,841,576.50	292,372,941.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	0.00	84,787,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	66,349,312.50	92,201,125.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,492,264.00	49,313,816.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	66,070,400.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	100,912,246.00	68,427,296.00
120	Нийтлэг татварын бус орлого	100,912,246.00	68,427,296.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	100,912,246.00	4,132,800.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	64,294,496.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,915,446,422.50	6,537,150,737.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,971,631,642.15	6,535,562,199.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,117,673,607.87	1,406,228,819.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	681,758,121.68	814,240,103.11
210101	Үндсэн цалин	390,082,035.68	473,431,155.00
210102	Нэмэгдэл	177,828,586.00	226,127,048.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	48,500,000.00	79,785,000.00
210104	Урамшуулал	65,347,500.00	34,896,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,562,795.06	104,523,774.33
210201	Тэтгэврийн даатгал	58,223,158.93	62,619,529.41
210202	Тэтгэмжийн даатгал	6,849,783.38	7,906,095.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,424,891.89	9,260,741.80
210204	Ажилгүйдлийн даатгал	3,612,991.89	3,952,920.80
210205	Эрүүл мэндийн даатгал	14,451,968.97	20,784,486.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,925,145.72	87,366,896.34
210301	Гэрэл, цахилгаан	3,203,194.17	3,901,231.86
210302	Түлш, халаалт	73,973,897.55	81,799,560.48
210303	Цэвэр, бохир ус	1,748,054.00	1,666,104.00
2104	Хангамж, бараа материалын зардал	140,350,301.32	78,189,955.00
210401	Бичиг хэрэг	10,391,800.00	10,197,750.00
210402	Тээвэр, шатахуун	17,239,000.00	11,867,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	556,600.00	418,400.00
210404	Ном, хэвлэл	38,000.00	38,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	650,000.00	550,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	111,474,901.32	5,903,027.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	49,215,678.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,120,000.00	0.00
210604	Урсгал засвар	1,120,000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	5,000,000.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	44,417,530.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	42,430,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	313,600.00

Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	83,860.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	1,482,200.00
210807	Газрын төлбөр	0.00	35,470.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	71,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	123,957,244.09	275,990,560.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,309,030.00	34,758,436.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	58,650,416.00	203,366,995.60
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,997,798.09	37,865,128.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,853,958,034.28	5,129,333,380.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,835,926,389.00	4,852,678,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,511,704,613.00	1,503,150,792.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,272,671,020.00	3,349,527,808.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	51,550,756.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,031,645.28	276,654,780.07
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,999,397.28	276,654,780.07
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	32,248.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,971,631,642.15	6,535,562,199.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(56,185,219.65)	1,588,537.56
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	77,747,001.00	165,882,902.50
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	77,747,001.00	165,882,902.50
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(77,747,001.00)	(165,882,902.50)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(133,932,220.65)	(164,294,364.94)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,814,534,176.50	6,451,723,441.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,710,692,600.00	6,176,350,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,710,692,600.00	6,176,350,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,841,576.50	275,372,941.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	0.00	84,787,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	66,349,312.50	92,201,125.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,492,264.00	49,313,816.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	49,070,400.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	600,000.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	600,000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	600,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	0.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	7,815,134,176.50	6,451,723,441.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,808,634,276.50	6,448,423,441.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	954,676,242.22	1,290,294,682.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	686,546,054.69	814,635,484.39
210101	Үндсэн цалин	322,962,001.00	432,970,926.92
210102	Нэмэгдэл	252,401,339.69	271,696,095.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	48,183,473.00	79,085,555.00
210104	Урамшуулал	62,999,241.00	30,882,907.00

Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,813,257.81	99,261,596.00
210201	Тэтгэврийн даатгал	62,571,157.81	65,227,496.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,060,500.00	8,507,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,030,300.00	4,254,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,030,300.00	4,254,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,121,000.00	17,017,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,925,145.72	87,603,500.00
210301	Гэрэл, цахилгаан	3,203,194.17	4,214,831.86
210302	Түлш, халаалт	73,973,897.55	81,722,564.14
210303	Цэвэр, бохир ус	1,748,054.00	1,666,104.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,219,200.00	9,195,977.00
210401	Бичиг хэрэг	2,337,700.00	2,122,350.00
210402	Тээвэр, шатахуун	9,736,162.00	4,055,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	576,600.00	298,000.00
210404	Ном, хэвлэл	38,000.00	38,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	650,000.00	532,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	880,738.00	2,150,027.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,611,300.00	0.00
210604	Урсгал засвар	9,611,300.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	5,000,000.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	44,211,330.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	42,690,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	83,860.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	1,329,600.00
210807	Газрын төлбөр	0.00	35,470.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	71,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,561,284.00	233,886,795.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,967,688.00	3,559,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	65,593,596.00	230,327,295.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,853,958,034.28	5,158,128,758.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,835,926,389.00	4,852,678,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,511,704,613.00	1,503,150,792.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,272,671,020.00	3,349,527,808.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	51,550,756.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,031,645.28	305,450,158.01
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,999,397.28	276,654,780.07
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	32,248.00	28,795,377.94
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)	7,808,634,276.50	6,448,423,441.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,499,900.00	3,300,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,499,900.00	3,300,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,499,900.00	3,300,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,499,900.00	3,300,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,499,900.00	3,300,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(6,499,900.00)	(3,300,000.00)
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	483,939,977.83	17,822,717.14	496,991,647.05	998,754,342.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	483,939,977.83	17,822,717.14	496,991,647.05	998,754,342.02
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(133,932,220.65)	(133,932,220.65)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	483,939,977.83	17,822,717.14	363,059,426.40	864,822,121.37
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	483,939,977.83	17,822,717.14	363,059,426.40	864,822,121.37
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	2,999,808.00	2,999,808.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	483,939,977.83	17,822,717.14	366,059,234.40	867,821,929.37
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(164,294,364.94)	(164,294,364.94)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	483,939,977.83	17,822,717.14	201,764,869.46	703,527,564.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	/төгрөгөөр/
				Хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,184,788,300.00	5,899,695,719.93	285,092,580.07	95.39
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,184,788,300.00	5,899,695,719.93	285,092,580.07	95.39
Татварын бус орлого	6,184,788,300.00	5,899,695,719.93	285,092,580.07	95.39
Тусламжийн орлого	6,184,788,300.00	5,899,695,719.93	285,092,580.07	95.39
Төсвөөс санхүүжих	6,184,788,300.00	5,899,695,719.93	285,092,580.07	95.39
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,184,788,300.00	5,899,695,719.93	285,092,580.07	95.39
НИЙТ ЗАРЛАГА	6,184,788,300.00	5,899,695,719.93	285,092,580.07	95.39
УРСГАЛ ЗАРДАЛ	6,184,788,300.00	5,899,695,719.93	285,092,580.07	95.39
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,080,530,000.00	1,047,017,119.93	33,512,880.07	96.90
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	817,455,500.00	794,323,316.93	23,132,183.07	97.17
Үндсэн цалин	439,509,800.00	427,806,088.92	11,703,711.08	97.34
Нэмэгдэл	293,437,900.00	256,548,766.01	36,889,133.99	87.43
Унаа хоолны хөнгөлөлт	48,910,200.00	79,085,555.00	(30,175,355.00)	161.70
Урамшуулал	35,597,600.00	30,882,907.00	4,714,693.00	86.76
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,274,500.00	99,261,596.00	6,012,904.00	94.29
Тэтгэврийн даатгал	71,240,400.00	65,227,496.00	6,012,904.00	91.56
Тэтгэмжийн даатгал	8,507,500.00	8,507,500.00	0.00	100.00
ҮОМШӨ-ний даатгал	4,254,500.00	4,254,500.00	0.00	100.00
Ажилгүйдлийн даатгал	4,254,500.00	4,254,500.00	0.00	100.00
Эрүүл мэндийн даатгал	17,017,600.00	17,017,600.00	0.00	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,603,500.00	87,603,500.00	0.00	100.00
Гэрэл, цахилгаан	5,187,400.00	4,214,831.86	972,568.14	81.25
Түлш, халаалт	80,109,900.00	79,917,199.08	192,700.92	99.76
Цэвэр, бохир ус	2,306,200.00	3,471,469.06	(1,165,269.06)	150.53
Хангамж, бараа материалын зардал	10,152,800.00	9,195,977.00	956,823.00	90.58
Бичиг хэрэг	2,356,500.00	2,122,350.00	234,150.00	90.06
Тээвэр, шатахуун	4,350,000.00	4,055,200.00	294,800.00	93.22
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	793,300.00	298,000.00	495,300.00	37.56

Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Ном, хэвлэл	38,000.00	38,000.00	0.00	100.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	582,400.00	582,400.00	0.00	100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,032,600.00	2,100,027.00	(67,427.00)	103.32
Томилолт, зочны зардал	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
Дотоод албан томилолт	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,018,000.00	44,211,330.00	806,670.00	98.21
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,690,700.00	42,690,700.00	0.00	100.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	313,600.00	0.00	313,600.00	0.00
Даатгалын үйлчилгээ	134,400.00	0.00	134,400.00	0.00
Тээврийн хэрэгслийн татвар	174,700.00	83,860.00	90,840.00	48.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	53,800.00	0	53,800.00	0.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,329,600.00	1,329,600.00	0.00	100.00
Газрын төлбөр	143,300.00	35,470.00	107,830.00	24.75
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	106,200.00	0.00	106,200.00	0.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	71,700.00	71,700.00	0.00	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	13,525,700.00	10,921,400.00	2,604,300.00	80.75
Бараа үйлчилгээний бусад зардал	3,559,500.00	3,559,500.00	0.00	100.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,966,200.00	7,361,900.00	2,604,300.00	73.87
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,104,258,300.00	4,852,678,600.00	251,579,700.00	95.07
Бусад урсгал шилжүүлэг	5,104,258,300.00	4,852,678,600.00	251,579,700.00	95.07
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,622,665,400.00	1,503,150,792.00	119,514,608.00	92.63
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,481,592,900.00	3,349,527,808.00	132,065,092.00	96.21
АЖИЛЛАГСДЫН ТОО	25	25	0	100.00
Удирдах ажилтан	1	1	0	100.00
Гүйцэтгэх ажилтан	21	21	0	100.00
Үйлчлэх ажилтан	3	3	0	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Боловсролын газар нь “Төрөөс боловсролын талаар баримталж буй бодлого шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлж боловсролын үйлчилгээг хүртээмжтэй чанартай, нээлттэй хүргэх, бие даан амьдрах иргэнийг төлөвшүүлэхэд боловсрол байгууллагын ажилтан албан хаагчдыг мэргэжлийн удирдлагаар хангаж, иргэд олон нийтийн оролцоог дэмжин ажиллах” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үнэллээ.

Тайлант онд Боловсролын яамнаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Боловсролын газар нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй БШУЯ-наас бэлтгэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Боловсролын газар нь 2025 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 703,622.4 мянган төгрөг болж өмнөх оноос 161,199.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	4,917.5	45,847.9	40,930.4
Урьдчилгаа	1.6	-	(1.6)
Бараа материал	68,131.0	18,568.6	(49,562.3)
Нөөцийн бараа	-	40,749.2	40,749.2
Үндсэн хөрөнгө	1,024,293.6	811,527.5	(212,766.1)
Хуримтлагдсан элэгдэл	(232,521.5)	(213,070.9)	19,450.6
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	864,822.1	703,622.4	(161,199.7)
Өр төлбөр	-	94.9	94.9
Засгийн газрын хувь оролцоо	864,822.1	703,527.6	(161,294.6)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	864,822.1	703,622.4	(161,199.7)

Авлага дансны үлдэгдэл өмнөх оноос 49,562.3 мянган төгрөгөөр өссөн нь НДШ-ийн авлага 4,865.0 мянган төгрөгөөр буурч, аймгийн ЗДТГ-аас чадварлаг багшийн төслийн санхүүжилт 17,000.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл төвлөрүүлэн татсан санхүүжилтийн авлага 28,795.4 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 18,568.6 мянган төгрөг болж өмнөх оноос 49,562.3 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд бараа материал төсвийн

Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

хөрөнгөөр бэлтгэсэн 37,406.2 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан юнивишний төхөөрөмж 750.0 мянган төгрөгөөр, шилжүүлэн авсан 53,918.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, зарцуулсан 61,298.1 мянган төгрөгөөр байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрээр акталсан 49,215.7 мянган төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 811,527.5 мянган төгрөг болж өмнөх оноос 212,766.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 3,300.0 мянган төгрөгөөр, Боловсролын яамнаас үнэ төлбөргүй хүлээн авсан 4,132.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 9/60 дугаар тогтоолоор 57,175.9 мянган төгрөгийн хөрөнгө акталсан, мөн 9/61 дугаар тогтоолоор балансаас балансад шилжүүлсэн газар 163,023.0 мянган төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 94.9 мянган төгрөг нь бараа үйлчилгээний бусад зардлын 94.6 мянган төгрөг, ажилчидтай холбогдсон 0.3 мянган төгрөгийн өр төлбөр байна.

Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаандаа Dynamic 1.0 программ хангамжийг ашиглаж, шалгалтын хариу засах 5,200.0 мянган төгрөгийн программ хангамжийг сургалтын албанд ашиглаж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 6,555,099.7 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 350,752.2 мянган төгрөгөөр бууруулж, 6,204,347.4 мянган төгрөгөөр баталсныг төсвийн тодотголоор 6,184,788.3 мянган төгрөгөөр тодотгожээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 6,184.788.3 мянган төгрөгийн санхүүжилт олгогдсоноос урсгал үйл ажиллагаанд 5,899.695.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
1	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	5,061,254.40	4,809,674.90	251,579.50	95.03
2	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,057,839.30	1,024,326.42	33,512.88	96.83
3	80220 Холбооны суваг ашигласны хөлс	22,690.70	22,690.70	0.00	100.00
4	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	43,003.90	43,003.70	0.20	100.00

Нийт дүн	6,184,788.30	5,899,695.72	285,092.58	95.39
----------	--------------	--------------	------------	-------

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тус байгууллага нь Боловсролын газрын хамтыг гэрээний 7.4 дэх заалтыг үндэслэн газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дугаар тушаалаар өдөрт 15.0 мянган төгрөгөөр букуу нийт 79,085.6 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийг олгосон байна.

Бүтэц орон тоог Боловсролын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар удирдах 1, гүйцэтгэх 21, үйлчлэх 3 албан тушаалтны орон тоог баталж, төсвийн тодотголоор орон тоог бууруулаагүй, гүйцэтгэлээр 794,323.3 мянган төгрөгийн цалингийн сантай 25 орон тоотой ажиллаж байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дулаанаар хангах гэрээг “ФЮМ” ХХК-тай 10,224.9 мянган төгрөгөөр, интернэтийн гэрээг “Юнивишн” ХХК-тай 10,530.0 мянган төгрөгөөр, сурах бичиг тээвэрлүүлэхээр “Модос трейд” ХХК-тай 10,000.0 мянган төгрөгөөр шууд худалдан авалт хийж гэрээ байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Боловсролын газар нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхзул гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Боловсролын газар нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Сонгосон суурь үзүүлэлт болох 2025 оны анхны батлагдсан төсөв 6,204,347.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож 62,043.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд тогтмол зардлыг 100 хувь зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2025 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 163 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан бөгөөд 3 мэдээллийг хоцроож, 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 3,691,034.8 мянган төгрөгийн 76 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 791,547.1 мянган төгрөгийн 39 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 522,067.3 мянган төгрөгийн 6 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно аудит хийгээгүй.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, аудитаар 1,377.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосон ба тус байгууллагаас 2025 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 308 дугаартай албан бичгээр аудитын шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлснийг хянаж үнэлсэн.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,377.5	1	1,377.5	100%
Нийт дүн	1	1,377.5	1	1,377.5	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сумдын сургуулийн биеийн тамирын багш нарт спортын цол, зэргийн нэмэгдлийг үндсэн цалингийн 10-15 хувиар тооцож олгож байна. Уг асуудлыг дараагийн аудитаар анхаарч авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

5.1 Албан шаардлага

5.1.1 Баянхонгор аймгийн боловсролын салбарын 15 байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулсан тушаал шийдвэр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, дараа жилийн төсвийн /зорилтот түвшин/ төсөл, санхүүгийн тайлан /хагас жил тутамд/, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ дутуу мэдээлсэн, хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг зөрчил илэрсэн байна. (Байгууллагын шилэн дансны зөрчлийн нэгтгэлийг хүснэгтээр оруулав.)

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5 дахь “Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа”, 6.4.5 дахь “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нөхөн байршуулж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд улирал бүр хяналт хэрэгжүүлж, 2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хэрэгжилтийг ирүүлж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Баянхонгор аймгийн боловсролын салбарын 15 байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын дарга, нягтлан бодогчийн нэр зөрүүтэй, байгууллагын төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулсан тушаал шийдвэр, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ дутуу мэдээлсэн, хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг зөрчил илэрсэн байна.	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		

-----oOo-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 89/А0571284/БНА-2026/НА-Номгон
СТА-Т43

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Боловсролын газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймгийн боловсролын салбарын 15 байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулсан тушаал шийдвэр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, дараа жилийн төсвийн /зорилтот түвшин/ төсөл, санхүүгийн тайлан /хагас жил тутамд/, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ дутуу мэдээлсэн, хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг зөрчил илэрсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5 дахь “Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа”, 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11

6426090285
/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:


1. Салбарын харьяа байгууллагуудын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст холбогдох мэдээллүүдийг нөхөн байршуулж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд улирал бүр дотоод хяналт хэрэгжүүлж, нотлох баримтыг 2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Боловсролын газрын дарга Л.Аюурзана, төсвийн төлөвлөлт, хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Намхайноров, төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн О.Алтансүх, нягтлан бодогч Д.Оюунтуяа нарт даалгав^{1,2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

АУДИТОР:



Г.ЭНХЗУЛ

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

² Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 89/А0571284/ БНА-2026/050/НА-СТА-ТШЗ дугаар албан шаардлагын хавсралт

Боловсролын байгууллагуудын шилэн дансны зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Тушаал, шийдвэр		Мэдээлээгүй				Хугацаа хоцроосон				Байршуулвал зохих мэдээ мэдээлэл		Нийт дүн
		Хугацаа хоцроосон		5 саяаас дээш орлогын гүйлгээ		5 саяаас дээш зарлагын гүйлгээ		5 саяаас дээш орлогын гүйлгээ		5 саяаас дээш зарлагын гүйлгээ		Мэдээлээгүй	Хугацаа хоцроосон	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн			
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	15	16
1	Баянговь сумын ЕБС			9	249,114.30	2	16,398.90							265,513.20
2	Баянговь сумын Цэцэрлэг			3	29,343.70									29,343.70
3	Баянлиг сумын Цэцэрлэг												Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал	-
4	Баян-Овоо сумын ЕБС												Дараа жилийн төсвийн төсөл, Аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	-
5	Баян-Овоо сумын цэцэрлэг											Худалдан авах ажиллагааны тайлан	Аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	-
6	Баянхонгор сумын 5 дугаар сургууль							1.00	32,304.90	3.00	85,388.70			117,693.60
7	Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэг			1	11,245.30	1	5,400.00						төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах шийдвэрийн 7 мэдээлэл	16,645.30
8	Баянхонгор сумын 9 дүгээр цэцэрлэг												Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	-
9	Баянхонгор сумын Баян-Ойт сургууль												Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-Хөтөлбөр, зориулалт, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангилал, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	-

A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	15	16
10	Баянхонгор сумын Баян-Ойт цэцэрлэг												Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-Хөтөлбөр, зориулалт, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангилал	
11	Бууцагаан сумын Баянбүрд багийн сургууль												Дараа жилийн төсвийн төсөл	-
12	Ерөнхий боловсролын Номгон сургууль												Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангилал	-
13	Жинст сумын ЕБС												Байгууллагын батлагдсан төсөв, Дараа жилийн төсвийн төсөл, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-Хөтөлбөр, зориулалт, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангилал	-
14	Шинэжинст сумын ЕБС	13	16,238.50	9	346,044.30	7	83,447.90					Худалдан авах ажиллагааны тайлан, дараа жилийн төсвийн /зорилтот түвшин/ төсөл, Санхүүгийн тайлан /хагас жил тутамд/ Санхүүгийн тайланд хийсэн	445,730.70	
15	Шинэжинст сумын Цэцэрлэг			4	26,189.00	9	176,714.00	3	176,714.00	18	420,999.90			800,616.90
		13	16,238.50	26	661,936.60	19	281,960.80	4	209,018.90	21	506,388.60			1,675,543.40